

**“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН  
11 ДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022.12.05

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТҮГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан батлуулсан нэгжүүдийн 11 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс							Хугацаа болоогүй	Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%			
ЗСХ	12	6	-	-	1	1	4	-	56.7	
ТНУАСХ	18	13	-	3	1	-	-	1	91.8	
ГХБАБМХ	6	6	-	-	-	-	-	-	100	
<b>Дүн</b>	<b>36</b>	<b>25</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>81.1</b>	

**Санал зөвлөмж:**

1. ЗТХ-ийн сайдын 2022.11.23-ны өдрийн “Гадаадад томилолтоор ажиллуулах тухай” А/307 дугаар тушаалын 3 дахь заалтыг хэрэгжүүлж БНСУ-д томилолтоор ажилласан тайланг ЗТХ-ийн сайдад албан бичгээр тайлагнах; **(Удирдлага, Г.Чангас)**

*ЗТХЯ-ны ТНБД-ын 2017.02.01-ний өдрийн 24 дүгээр тушаалаар баталсан “ЗТХЯ-ны албан хаагчид, салбарын харьяа агентлаг, байгууллагын дарга, дэд дарга нарыг гадаадад томилолтоор ажиллуулах журам”-ын 2-р хавсралтаар баталсан загварын дагуу журмын 6.7-д зааснаар “...томилолтын хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Сайдад албан бичгээр ирүүлж тайлагнана.” гэж заасан. Энэ хугацаа 2022.12.07-ны /лхагва гараг/ өдрөөр дуусгавар болж байна.*

2. ЗТХЯ-наас зохион байгуулах харьяа байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны тайлан хамгаалах арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж танилцуулга презентацид тусгах тоон үзүүлэлт, мэдээллийн агуулгыг удирдлагад танилцуулж чиглэл авах, боловсруулах; **(Т.Мейрамбек, Нийт ажилтан)**

3. ЗТХЯ-наас салбарын онцлох ажлыг нэгтгэж олон нийтэд танилцуулахаар төлөвлөж байгаатай холбогдуулан төвийн хэмжээнд 2022 онд зохион байгуулсан онцлох ажлын танилцуулга, хүрсэн үр дүн, зураг, видео, тайланг 12 дугаар сарын 12-ны дотор, 2022 оны үйл ажиллагааны тухай видео контентыг 12 дугаар сарын 15-ны дотор ЗТХЯ-ны БТГ-т танилцуулах; **(Д.Амарзаяа)**

4. ЗТХЯ-ны 2022.06.10-ны “Зөвлөмж хүргүүлэх тухай” 08/2726, 2022.11.18-ны “Үүрэг даалгаврын хэрэгжилтийг сайжруулан дахин ирүүлэх тухай” 08/5359 тоотод дурдсан зурмагийн тасалдлыг бууруулах санал шийдэлийг ТЗДТБХЗГ-т танилцуулах; **(Б.Буманцэцэг)**

5. ЗТХ-ийн сайдаас өгсөн “Төвийн үйл ажиллагаатай холбоотой гадаад орны ижил төстэй байгууллагын туршлагыг судалж, харьцуулалт гаргаж танилцуулах” үүрэг даалгаврын хүрээнд хийгдсэн судалгааг сайжруулж дахин боловсруулж ТЗДТБХЗГ-т танилцуулах; **(Г.Баттөр)**

6. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаарх саналыг ТЗДТБХЗГ-т хүргүүлэх; **(Г.Чангас)**

7. ЗТХ-ийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтэд онцгой анхааран ажиллаж хэрэгжилтийг сар бүр ТЗУГ-т албан бичгээр тайлагнах; **(Д.Амарзаяа)**

8. ЗТХЯ-ны ХШҮДАГ-аас нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт цахим шуудангаар ирсэн даруйд 46 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг холбогдох ажилтнаас авч нэгтгэн, удирдлагад танилцуулж тогтоосон хугацаанд тайлагнах; **(Д.Амарзаяа)**

9. ЗТХЯ-ны ТЗУГ-ын 2022.11.07-ны 05/5124 тоотод дурдсан иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан ажлын мэдээллийг 14 хоног тутамд, заасан маягтаар пүрэв гараг бүр [munkhbulgan@mrt.d.gov.mn](mailto:munkhbulgan@mrt.d.gov.mn) цахим шуудангаар хүргүүлж байх; **(Д.Амарзаяа)**

10. ЗТХ-ийн сайдын 2022.03.09-ний өдрийн “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх тухай” А/50 дугаар тушаал, ЗТХЯ-ны ТЗУГ-ын 2022.04.29-ний “Өргөдлийн шийдвэрлэлтийг эрчимжүүлэх тухай” 05/1981 тоот албан бичгийн хүрээнд төвийн хэмжээнд өргөдөл номдол, хариутай албан бичиг шийдвэрлэлтийн тайланг жилийн эцсийн байдлаар ТЗУГ-т тайлагнах, цахим хуудсанд байршуулж мэдээлэх; **(Г.Байгалмаа)**

11.ЗТХЯ-ны ТНБД-ын 2022.03.07-ны “Хүртээмжийг нэмэгдүүлэх тухай” 03/1041 тоотын хариуг ЗТХЯ-нд хүргүүлэх; **(М.Оюун-Ундрэм)**

12.ЗТХЯ-ны ТНБД-ын 2022.02.16-ны 03/668 тоотын хариу болох хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ЗТХЯ-ны БТГ-т жилийн эцсээр тайлагнах; **(Эцэг эхийн зөвлөл)**

13.ЗТХЯ-ны ТНБД-ын 2022.01.20-ны “Зөвлөмжийн хэрэгжилт хангах тухай” 03/259 тоотын хариуг жилийн эцсийн байдлаар нэгтгэн тайлагнах; **(Э.Осоржамаа)**

14.Төвийн 2022 оны гүйцэтгэлийн болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтад заасан байгууллагын болон зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн тайлангийн загварын дагуу тайлагнах; **(Нийт ажилтан)**

<http://rtcc.mrtd.gov.mn/file/32>

<http://rtcc.mrtd.gov.mn/upload/files/566c8b02c5d5df56b5426b0d7d7f6e6e.pdf>

**(Төвийн 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ЗТХЯ-нд тайлагнах сүүлийн хугацаа 2022.12.10-ны өдөр - нэгтгэх, танилцуулах, хэлэлцүүлэх, засварлах хугацаа шаардагдана шүү)**

15.Хөдөлмөрийн дотоод журмын 5.1.3, 5.1.5-д заасны дагуу төвийн 2023 оны болон нэгжүүдийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралтад заасан аргачлал, загварын дагуу боловсруулах; **(Нийт ажилтан)**

<http://rtcc.mrtd.gov.mn/upload/files/c96ce12c05d87c9125fe482d2ac321a8.pdf>

<http://rtcc.mrtd.gov.mn/upload/files/1af87cce25aa22ad321b0f45858a13a0.pdf>

**(Төвийн 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-нд тайлагнах сүүлийн хугацаа 2022.12.15-ны өдөр - нэгтгэх, танилцуулах, хэлэлцүүлэх, засварлах хугацаа шаардагдана шүү)**

16.Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг яаралтай боловсруулж батлуулан ажилтнуудын ажлын үр дүнг үнэлж дүгнэх арга хэмжээг зохион байгуулах, журмын төсөлд дараах зохицуулалтыг тусгах: **(М.Оюун-Ундрэм)**

- Ажил цалгардуулсан, үүрэг даалгавар биелүүлээгүй, төлөвлөгөөт ажил тасалдсан, удааширсан бол хариуцлага тооцох зохицуулалтыг тусгах

- Гүйцэтгэлийн үнэлгээг 0-29% хийгдсэн бол үр дүнгүй, 30-59% хийгдсэн бол эрчимжүүлэх шаардлагатай, 60-89% хийгдсэн бол тодорхой үр дүнд хүрсэн, 90-100% хийгдсэн бол төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж үзэх

- Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ төлөвлөлтийн алдаатай бол сул төлөвлөлт гэж үзэн үнэлгээг бууруулах

- Тайлагнал дутуу бол үнэлгээг бууруулах

- Хугацаандаа тайлагнаагүй бол үнэлгээг бууруулах

- Нэмэлт ажил нь төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй давхцаагүй бол ажлын цар хүрээг харгалзан, түүнчлэн удирдлагаас өгсөн үүрэг даалгавруудыг нэгтгэн дундаж хувиар тооцож үнэлэх

- Мэдлэг чадвараа дээшлүүлэх, хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээг нэмэлтээр тусгах

- Ажлын цаг ашиглалтын оноог өндөрсгөх

17. Албан тушаалын тодорхойлолтуудыг яаралтай батлуулах (**М.Оюун-Ундрэм**)

**ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ

ТНУАСХ-ИЙН ДАРГА



Д.ТӨГСЖАРГАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮМ



Э.ОСОРЖАМАА